



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 16 өдөр

Дугаар 0110

Жавхлант

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2022 оны 02-р тогтоол (байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам)-ын 3.5.1 дэх заалт, сумын ИТХ-ын 2024 оны 12 сарын 30-ны өдрийн 03 дугаар хуралдааны А/19 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хөрсний цөлжилт, доройтлоос сэргийлэх газрын төлөвлөгөөт хянан баталгаанд 11.298.000 (арван нэгэн сая хоёр зуун ерөн найман мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг байгалийн нөөц ашигласан орлогоос зарцуулахыг Нягтлан бодогч (Э.Уранбайгаль)-д зөвшөөрсүгэй.

3.Газрын төлөвлөгөөт хянан баталгааны хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Шаравгаваа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.БАТЧУЛУУН